



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар A/543

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах, ажлын байрны
байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 2.6.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 9 дүгээр сарын 28-ны хуралдааны шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.


2. Хэрлэн сумын 3 дугаар багт үйл ажиллагаа явуулж байсан “Бумбат” ХХК-ийн эмийн сангийн ажлын байрны байршлыг Хэрлэн сумын 3 дугаар багт байрлах “Хишиг” үйлчилгээний төвийн байранд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг дарын, 2022

оны 10 дугаар сарын 27-ны

дугаар захирамжийн хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
явуулах тусгай зөвшөөрлийг сунгасан байгууллагуудын нэрс

№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Хэрлэн сум "Пиавка" уламжлалтын үүдэн эмнэлэг	3 жил	2022 оны 10 дугаар сарын 21- 2025 оны 10 дугаар сарын 21
2	Хэрлэн сум "Хашцагаан сувд" шүдний үүдэн эмнэлэг	3 жил	2022 оны 10 дугаар сарын 21- 2025 оны 10 дугаар сарын 21
3	Дэлгэрхаан сум "Дархан оточ аварга" рашаан, сувилал	3 жил	2022 оны 9 дүгээр сарын 28- 2025 оны 9 дүгээр сарын 28
4	Бор-Өндөр сум "Монавит" ХХК-ийн эмийн сан	2 жил	2022 оны 10 дугаар сарын 22- 2024 оны 10 дугаар сарын 22
5	Бор-Өндөр сум "Азын нахиа" ХХК-ийн эмийн сан	2 жил	2022 оны 10 дугаар сарын 22- 2024 оны 10 дугаар сарын 22